

## **АГУУЛГА:**

1. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДАА ЭРХЭЛДЭГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ
2. АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ
3. УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ
4. СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ 2022-07-05
5. ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ
6. АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

### **ӨНДӨРШИЛ СУМЫН СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДАА ЭРХЭЛДЭГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж байгууллага	Зөвшөөрөл олгосон газар	Зөвшөөрлийн дугаар	Зөвшөөрөл олгосон огноо
1	Чебу ХХК Хүнсний дэлгүүр	Аймгийн Засаг дарга	2022/07	2022-05-25
2	Чебу ХХК Зоогийн газар	Аймгийн Засаг дарга	94	2020-09-22
3	Шилийн хурд ХХК супермаркет	Аймгийн Засаг дарга	37	2020-06-10
4	Тасын хашаат ХХК Хүнсний дэлгүүр	Аймгийн Засаг дарга	29	2021-12-24
5	Мөнхдүүрэн Арвай ХХК Хүнсний дэлгүүр	Аймгийн Засаг дарга	36	2020-09-22
6	Мөнхдүүрэн Арвай ХХК Тамхины цэг	Сумын Засаг дарга	A/36	2021-07-09
7	У.Оюунцэцэг Тамхины цэг	Сумын Засаг дарга	A/164	2021-07-30

### **АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ**

Ашиглалтын болэн хайгуулын 26 аж ахуйн нэгж байна. Үүнээс 7 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй.

### **УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ 2010-11-25**

35.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.2.1.согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 1 500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 1 000 000 төгрөг, бусад суманд 500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 300 000 төгрөг, бусад суманд 200 000 төгрөг;

35.2.2.11.00-22.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 1 000 000 төгрөг, аймгийн төвийн суманд 500 000 төгрөг, бусад суманд 300 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 300 000 төгрөг, бусад суманд 100 000 төгрөг;

## **СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ 2022-07-05**

### **15 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл**

15.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 15.7-д заасан тусгай зөвшөөрлийн тоонд нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд чөлөөт бүсийн захирагч олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.

15.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг Засгийн газар батална.

15.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тухай бүр сунгана.

15.4.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ авсан согтууруулах ундааг худалдана.

15.5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад энэ хуулийн 15.2-т заасан журмыг баримтална.

15.6.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлийг бэлэглэх, худалдах, барьцаалах, түрээслэх зэргээр бусдад шилжүүлэх болон энэ хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулах байршлыг өөрчлөхийг хориглоно.

15.7.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.

15.8.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 15.1-д заасан эрхээ сум, дүүргийн Засаг дарга, эсхүл доод шатны албан тушаалтанд шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

15.9.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, цахим төлбөрийн баримтын системд холбогдсон, татварын байгууллагад хугацаа хэтэрсэн өргүй этгээдэд олгоно.

## **СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ**

/Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн  
2019 оны 05 дугаар тогтоолын хавсралт /

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийж, хяналт тавих, тэдний үйл ажиллагаа явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын стандартыг мөрдөж ажиллана.

1.3.Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Татварын хэлтэс, сумдын Засаг дарга нар зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Хоёр. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага

2.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дараах шаардлагыг хангаж, тусгай зөвшөөрөл авсан нөхцөлд энэхүү үйл ажиллагааг эрхэлж болно.

2.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, аймгийн нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэр, мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагчийн хууль ёсны албан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж, хэрэгжилтийг ханган ажиллана.

2.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх байгууллага нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу баригдсан барилга байгууламж, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, барааны чанар, аюулгүй байдал, технологи, ариун цэвэр эрүүл ахуйн үндсэн шаардлагыг хангасан байранд үйл ажиллагаа явуулна.

2.4.Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь стандартын шаардлага хангасан, зөвшөөрөлд заагдсан агууламж бүхий бүтээгдэхүүнээр худалдаа, үйлчилгээг эрхлэн явуулна.

2.5.Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үндсэн ажилтан нь хөдөлмөрийн гэрээ байгуулсан, нийгмийн даатгал төлдөг, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлөөр хангагдсан харилцааны өндөр соёлтой, мэргэжлийн үнэмлэхтэй, эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан, ажилтны нэр бүхий энгэрийн тэмдэг, иж бүрэн хувцастай байх бөгөөд “Хэрэглэгчээ дээдлэе” зарчмыг баримтлан ажиллана.

2.6.Орон сууцны зориулалтыг өөрчлөн ажил үйлчилгээ явуулахаар зориуд тохижуулсан, эсхүл анхны зориулалт нь үйлдвэрлэл, үйлчилгээний төлөвлөгдсөн худалдаа, үйлчилгээний газар нь оршин суугчдын 90 хувийн саналыг авсан байна.

2.7.Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага нь кассын машин, барааны зураасан код унших тооцооны машинтай, үйлчилгээний хэсэгтээ галын дохиоллыг заавал байрлуулсан, дотор, гаднах орчныг хянах MNS6423:2013 стандартын шаардлагыг хангасан хяналтын шөнийн цагаар зураг авдаг, бичлэгийг 30 хоног хадгалдаг санах ойтой телекамертай байна.

2.8.Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй, татвар санхүүгийн тайлангаа цаг хугацаанд нь гаргаж хэвшсэн, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу сайн дураараа нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлж, нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж байна.

2.9.Үйл ажиллагаа явуулж буй объектынхоо эргэн тойрны 50м газрын цэвэрлэгээ болон хотын тохижилт, соёлжилтод онцгой анхаарч ажилласан байна.

2.10.Байгууллага бүр өөрийн нэр, лого бүхий орчин үеийн шаардлага, стандартад нийцсэн гэрлэн хаяг, цагийн хуваарийг монгол хэл дээр, крилл үсгээр бичиж харагдахуйц байршуулж, гадна гэрэлтүүлгийг 10-20 м-т байгаа эд зүйл харагдах, бичлэгт орж байхаар шийдсэн байна.

2.11.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.2 дугаар заалтыг болон өөрийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй хууль, дүрэм, журам, стандартын талаар хуулийн булан /1.0\*1.2м хэмжээтэй/-д хуульд тусгагдсан холбогдох заалтууд, архи, согтууруулах ундаа байршуулж буй хэсгийн ард, зурагт хуудсыг харагдахуйц газарт байршуулсан байна.

2.12. Аймаг, сумын хэмжээнд согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхлэхийг хориглосон өдрүүд, цагуудад согтууруулах ундааны хэсгийг бүрэн хаах хэвлэмэл хөшигтэй, хөшгөн дээр Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, аймаг, сумын Засаг даргын захирамжийн холбогдох заалт, зөвлөмж, сэрэмжлүүлгийг үйлчлүүлэгчийн нүдэнд тод харагдахаар бичсэн байна.

2.13. Аймаг орон нутагт зөвшөөрөгдсөн согтууруулах ундааг шинжилгээний бичигтэй худалдаалах ба импортын архи согтууруулах ундааны гаалийн шинжилгээний бичгийг бүрэн бүрдүүлсэн байна.

2.14. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх газрууд нь үйлчилгээний онцлогийг тусгасан дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.14.1. Согтууруулах ундаа худалдах газар

2.14.1.1.Согтууруулах ундаа худалдах газрууд нь “Худалдааны газар, түүний үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5021:2007

2.14.1.2.Согтууруулах ундаа худалдах газрын үйлчилгээний заалны талбайн хэмжээ 45 м.кв-аас дээш байх бөгөөд зориулалтын агуулах, ажиллагсдын амрах өрөөтэй байна.

2.14.1.3.Согтууруулах ундааны төрлийг бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн, ундаанаас тусад нь байрлуулсан байна.

2.14.2.Согтууруулах ундаагаар үйлчлэх “Зоогийн газар”

2.14.2.1.Зоогийн газар нь ариун цэврийн дүрмийн шаардлага хангахуйц хоол зөөх болон хэрэглэсэн аяга таваг зөөх урсгалтай, үйлдвэрлэлийн байр нь технологийн шаардлагад нийцсэн бэлтгэлийн өрөө, халуун болон хүйтэн боловсруулах цехтэй эсвэл зориулалтаар зохион байгуулагдсан ажлын байртай байна.

2.14.2.2..Зоогийн газар нь хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ “Хоолны газрын ангилал, зэрэглэл, ерөнхий шаардлага MNS 4946:2005” стандартыг чанд баримтлана.

2.14.2.3.Согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх газрын үйлчилгээний заал нь 50 м.кв-с дээш талбайтай үйлчилгээний газарт агаар оруулах, гаргах төхөөрөмжтэй, 28 хүн тутамд гарын угаагуур 1, эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 суултуур ногдохоор байна.

2.14.3..Согтууруулах ундаагаар үйлчлэх “Кафе”

2.14.3.1.Кафе нь энгийн байхаас гадна төрөлжсөн байж болно. Төрөлжсөн кафе нь нэрэндээ тохирсон дотоод, гадаад тохижилттой, өөрийн онцлогыг агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулах үйлчилгээтэй байна.

2.14.3.2.Хүүхдэд зориулсанаас бусад төрөлжсөн кафед 18-аас дээшгүй градустай дарс, шар айргаар үйлчилнэ.

2.14.3.3.Кафе зөвхөн стандартын шинжилгээ, чанарын баталгаатай бараа бүтээгдэхүүнийг горимын дагуу хадгалан, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулна.

2.14.3.4.Кафе "Хоолны газрын ариун цэврийн дүрэм"-ийг баримтлан ажиллаж, цэвэрлэгээ, ариутгал устгалыг тогтмол хийж ажиллана.

2.14.4.Согтууруулах ундаагаар үйлчлэх “Баар”

2.14.4.1.Баар зөвхөн согтууруулах ундаагаар үйлчлэх, хэт чанга хөгжим тавих, нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, хэрүүл зодоон гаргах зэрэг үйлчилгээний дэг журам зөрчсөн зохисгүй байдал гаргахгүй байх зарчмыг хатуу баримтлана.

2.14.4.2.Баар нь хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ хоолны газрын ангилал, зэрэглэл, ерөнхий шаардлага MNS 4946:2005 стандартыг чанд баримтлана.

2.14.4.3.Бармены ажлын байр, угаалгын тосгуур, ус буцалгагч, хөргөгч, мөс бэлтгэгч, коктейль найруулагч, шилэн сав хэрэглэлийн тавиур зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

2.14.4.4.Хувь хүн, аж ахуйн нэгжээс стандартын бус, шинжилгээгүй, хаана үйлдвэрлэсэн нь тодорхойгүй, онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундааг хүлээн авч худалдаалахгүй байна.

2.14.4.5.Баар нь согтууруулах ундаа болон халуун хоол, зуушаар үйлчлэхээс гадна хүмүүсийн ая тухтай амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор караоке, шоу тоглолт, биеийн тамир, соёл урлагийн чиглэлийг сурталчлах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж ажиллана.

Гурав. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлт

3.1.Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг: Үүнд:

3.1.1.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/

3.1.2.Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

3.1.3.Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

3.1.4.Үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх

3.1.5.Бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нь эрүүл, аюулгүйн бүхий л стандартын шаардлага хангаж бүтээгдэхүүн үйлчилгээ нь “Тохирлын гэрчилгээ”-ээр баталгаажсан байх

3.1.6.Татварын улсын байцаагчийн санал дүгнэлт, Татварын албаны тодорхойлолт, /Санхүүгийн тайлангаа баталгаажуулж, татвараа үнэн зөв тодорхойлон хуулийн хугацаанд төлдөг байх/

3.1.7.Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн худалдаа үйлчилгээний газарт хийгдсэн Мэргэжлийн хяналтын газрын байцаагчийн эрсдэлийн үнэлгээний хуулбар

Дөрөв. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

4.1.Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж нь холбогдох баримт материалаа бүрдүүлж тухайн сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлж, сумын Засаг дарга аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хуулийн хугацаанд хянан саналаа аймгийн Засаг даргад ирүүлнэ.

4.2.Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авсанаас хойш 21 хоногт багтаан шийдвэрлэх ба дахин нягтлан судлах шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж болно.

4.3.Нэг аж ахуйн нэгжийн нэр дээр 2-оос илүү цэгт тусгай зөвшөөрөл олгохгүй.

4.4.Тусгай зөвшөөрлийг олгохдоо Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс олгосон тохирлын гэрчилгээтэй, улсын стандартын шаардлагыг 90-100 хувь хангасан, мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдлийн үнэлгээгээр бага  $\leq 29\%$  эрсдэлтэй үнэлэгдсэн аливаа зөрчилгүй ажиллаж ирсэн аж ахуйн нэгжид хоёр жилийн хугацаатай олгоно.

4.5.Тусгай зөвшөөрлийг хоёр жилийн хугацаатай олгож, гэрчилгээгээр баталгаажуулна. /Жич:Тусгай зөвшөөрлийг улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг аялал жуулчлалын газрууд 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зөвхөн тухайн үйлчилгээний газарт ашиглана./

4.6.Тусгай зөвшөөрлийн нормативыг хүн амын тоонд харьцуулан зөвхөн худалдаа эрхлэх зөвшөөрөл олгоход баримтална.

Тав. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

5.1.Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

5.2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгасан тохиолдолд аймгийн Засаг даргын захирамжаар тусгай зөвшөөрлийг 1 удаа сэргээх бөгөөд холбогдох хууль, тогтоомжийг дахин зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох ба тухайн аж ахуйн нэгжид “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл”-ийг дахин олгохгүй.

Зургаа. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах

6.1.Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс олгосон тохирлын гэрчилгээтэй, улсын стандартын шаардлагыг 90-100 хувь хангасан, мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдлийн үнэлгээгээр бага / $\leq 29\%$ / эрсдэлтэй үнэлэгдсэн аливаа зөрчилгүй ажиллаж ирсэн аж ахуйн нэгжийн зөвшөөрлийг хоёр жилийн хугацаатай сунгана.

6.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай 13 дугаар зүйлийн 13.1-д заасан нөхцөл байдал илэрсэн болон энэхүү журмын 3-д тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаж байсан талаарх мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллага болон орон нутгийн удирдлагын тодорхойлолтыг үндэслэн шийдвэрлэнэ.

6.3.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хуулийн хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө аймгийн Засаг даргад хүсэлтээ гаргана. Хүсэлт гаргасанаас хойш төрийн байгууллагын шийдвэр гаргах хүртэл аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа хэвийн явуулна.

Долоо. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

7.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан үндэслэлийг зөрчсөн.

7.2.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 5 дугаар зүйлийн 5.9, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь заалтыг зөрчсөн.

7.3.Татвар санхүүгийн тайлангаа цаг хугацаанд нь гаргаж хэвшээгүй, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу сайн дураараа нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлээгүй, нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг бүрэн хэрэгжүүлээгүй.

7.4.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг бусдад бэлэглэсэн, барьцаалсан, худалдсан, түрээслүүлсэн, үүсгэн байгуулагчийн нэр өөрчлөгдсөн, бусдад шилжүүлсэн.

7.5.Онцгой, өндөржүүлсэн бэлэн байдал зарлах зэрэг нийтийг хамарсан захирамж, тушаал гарсан үед захирамжийн биелэлтийг зөрчсөн.

7.6.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх журам зөрчсөн тухай орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагын хяналт, шалгалтын дүн, саналыг тус тус үндэслэнэ.

7.7.Энэхүү журмын шаардлагыг 2 удаа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох бөгөөд хуулийн хүрээнд ноцтой зөрчил дутагдал гаргаагүй бол тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө цуцлахгүй байх чиглэл баримтлах ба гаргасан зөрчил дутагдлаа зассан эсэх нь хугацаа сунгахад нөлөөлнө.

Найм. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналт, хамтын ажиллагаа

8.1.Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хүсэлтийг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгээр хэлэлцүүлэн хуралдааны дүгнэлтийг Аймгийн Засаг даргад танилцуулан шийдвэрлүүлнэ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга захирамжаар батална.

8.2.Захирамжийг 3 хоногийн дотор Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Онцгой байдлын газар, сумдын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх болон Вэб сайтад тавьж олон нийтэд мэдээлнэ.

8.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх талаар тогтоосон журмын хэрэгжилтэд аймгийн Засаг дарга, сум, багийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Татварын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмаар олгосон эрх, хэмжээний хүрээнд хяналт тавина.

8.4.Сумдын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, орон нутагт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийж, үр дүнгийн талаарх мэдээллийг хагас жил тутамд Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлнэ.

8.5.Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжилзүйн хэлтэс, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Онцгой байдлын газар зэрэг мэргэжлийн байгууллагууд энэхүү журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, аймгийн Засаг даргад хяналт шалгалтын талаарх дүн мэдээлэл, тэмдэгтийн хураамжийн тайланг хавсралт 3 дугаар маягтын дагуу гаргаж сумын татварын байцаагчтай тооцоо нийлж хагас бүтэн жилээр тайлагнаж тайланг дараа сарын 15-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлнэ.

8.6.Энэхүү журмын хэрэгжилтийг хангахад сумын Засаг дарга, мэргэжлийн байгууллагууд тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид хяналт тавихаас гадна хамтран ажиллаж дэмжлэг үзүүлнэ.



8.7.Эрх бүхий мэргэжлийн байгууллагууд нь үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хязгаарлах, хүнсний дэлгүүр, зоогийн газар, баар, кафе зэрэг газарт архи, согтууруулах ундаанаас өөр төрлийн үйлчилгээ үзүүлэхэд нь үүд хаалгыг цоожлох, хаах зэрэг хуулиар олгогдоогүй таслан сэргийлэх үйл ажиллагаа явуулах эрхээр хангагдахгүй.

8.8.Архинд донтогчдыг эмчлүүлэх, эрүүлжүүлэх, нийгэмшүүлэхтэй холбоотой ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж шийдвэрлэнэ.

## Ес. Хариуцлага

9.1. Хууль тогтоомжийг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага нь Зөрчлийн тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

9.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэргэжлийн байгууллагын тодорхойлолт болон бусад мэдээллийг хууль бусаар гаргасан, хувийн ашиг сонирхлын зөрчилтэй мэдээллийг ирүүлсэн нь тогтоогдвол тухайн төрийн албан хаагчид холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцуулах саналыг түүнийг удирдах албан тушаалтанд хүргүүлнэ.

9.3. Журмын хэрэгжилтэнд Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, сумдын Засаг дарга нар хяналт тавина.

Арав. Журам хүчин төгөлдөр болох

10.1. Энэхүү журам нь Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 -ын дагуу захиргааны хэм хэмжээний актаар бүртгэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

## **ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ 2005-07-01**

7.3.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.

## **УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ 2010-11-25**

35.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.1.5.тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход 100 000-500 000 төгрөг;

## **АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ**

/ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын

2022 оны 04 сарын 12–ны өдрийн А/67 дугаар тушаалын хавсралт/

## НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү "Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам" (цаашид "Журам" гэх)-ын зорилго нь Ашигт малтмалын тухай хуульд заасан үндэслэлээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг (цаашид "Тусгай зөвшөөрөл" гэх) олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг олон нийтийн хяналтын дор ил тод, нээлттэй, шударга өрсөлдөх, тэгш боломжоор хангах зарчмыг баримтлан зохион байгуулна.

1.3.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "АЛСЫН ХАРАА-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24.-т "Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ" гэж заасан бодлогыг баримтлан Ашигт малтмалын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус нийцүүлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

1.4.Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг Ашигт малтмалын тухай хууль болон энэ журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулна.

ХОЁР. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалтын талбайг бэлтгэх, нийтэд зарлах

2.1.Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь Засгийн газрын баталсан талбайгаас Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5.2, 17.5.3, 17.6-д заасан шаардлагад нийцүүлж, сонгон шалгаруулалтын талбайг ялгах болон давхцлыг шалгаж Үндэсний геологийн албанд хүргүүлнэ.

2.2.Үндэсний геологийн алба нь энэ журмын 2.1-д заасан талбайд Ашигт малтмалын тухай хуулийн 17.5.1, 17.7-д заасан шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулалт явуулах талбайн геологийн суурь судалгааны ажлын ерөнхий мэдээллийг боловсруулж, Улсын төсвийн хөрөнгөөр судлагдсан ордын нөөц, баялаг, эрдсийн хуримтлал тогтоогдсон эсэхийг нягтлаад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.

2.3.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь энэ журмын 2.1, 2.2-т заасны дагуу бэлтгэсэн бүх талбайг хянаж, зарлах талбайг эцэслэж, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.4. Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь журмын 2.3-т эцэслэгдсэн бүх талбайн сонгон шалгаруулалтын урилгыг нийтэд, жил бүрийн эхний улиралд багтаан, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр зарлана.

2.5.Сонгон шалгаруулалтын урилгад дараах мэдээллийг тусгасан байна:

2.5.1.сонгон шалгаруулалтын талбайн тодорхойлолт /Талбайн дугаар, талбайн байрших аймаг, сум, талбайн нэр, хэмжээ, солбицол/;

2.5.2. талбайн байршлыг харуулсан зураг;

2.5.3. хүсэлтийг бүртгүүлэх цахим хуудас, холбоос хаяг, холбогдох лавлах утасны дугаар;

2.5.4. Хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа;

2.5.5. сонгон шалгаруулалтын талбайн босго үнийн дүн, түүнийг байршуулах дансны дугаар;

2.5.6. үйлчилгээний хураамж, дансны дугаар;

ГУРАВ. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх, багцлах

3.1. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт, үнийн санал болон техникийн саналыг бүртгүүлэхэд дараах журмыг баримтална:

3.1.1. оролцогч сонгон шалгаруулалтын цахим системд нэвтэрч (Цахим систем гэх), Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5-д заасан үйлчилгээний хураамжийг урилгад заасан зааврын дагуу төлснөөр тухайн сонгон шалгаруулалтын талбайн багц мэдээлэлтэй танилцах, Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасан хүсэлт (цаашид хүсэлт гэх) бүртгэх холбоос цэсийг ашиглах эрхтэй болно;

3.1.2. оролцогч нь цахим системд байрлах Сонгон шалгаруулалтын хүсэлт бүртгэх холбоос цэсийг ашиглан босго үнийг төлж, үнийн санал болон техникийн саналыг бүрэн бөглөж хавсаргаж цахимаар бүртгүүлнэ;

3.1.3. оролцогч нь тухайлсан талбайн сонгон шалгаруулалтад өрсөлдөх Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5-д заасан үнийн саналын дүнг талбайн босго үнийг оролцуулан бүртгэлийн цахим системд байгаа цонхонд тоо болон үсгээр зөрүүгүй бичиж бөглөнө;

3.1.4. сонгон шалгаруулалтын талбайн босго үнэ гектар тутамд 4500 төгрөгөөр илэрхийлсэн мөнгөн дүн байхаар тооцно.

3.1.5. оролцогч сонгон шалгаруулалтын урилгад заасан хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө энэ журмын 3.1.2-т заасны дагуу бүрэн бөглөж, энэ журмын 3.1.3-т заасан босго үнийг бүрэн гүйцэд төлж илгээснээр тусгай кодоор баталгаажсан, огноо бүхий хүсэлт хүлээн авсан тодорхойлолт оролцогчдод илгээгдэж бүртгэл хүчинтэй болно;

3.1.6. оролцогч нь баримт бичигт заасны дагуу техникийн санал (Журмын 1, 2, 3 дугаар хавсралтуудын хамт)-ыг боловсруулан, электрон хэлбэрээр буюу "pdf" форматад гаргацтай, тод хөрвүүлэн, хүсэлт хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээнэ.

3.2. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг цахим системээр багцлахдаа дараах журмыг баримтална:

3.2.1. цахим систем нь Сонгон шалгаруулалтад оролцох нийт хүсэлтийг хүлээн авч бүртгэл хаагдсаны дараа хүсэлт ирүүлсэн хугацаагаар эрэмбэлж, жагсаалт-тэмдэглэлийг гаргана. Үүнд:

3.2.1.1. хүсэлт ирээгүй талбай;

3.2.1.2. нэг талбайд нэгээс илүүгүй хүсэлт ирүүлсэн жагсаалт;

3.2.1.3. нэг талбайд 2 болон түүнээс дээш санал ирүүлсэн жагсаалт.

3.2.2. Энэ журмын 7.1.1-д заасан Комисс нь хүсэлт ирүүлээгүй талбайн жагсаалтыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

3.2.3 Комисс нь журмын 3.2.1.2-д заасан нэг талбайд нэг хүсэлт ирүүлсэн тохиолдолд материалын бүрдвэрийг шалгаж, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

3.2.4. Комисс нь журмын 3.2.1.3-д заасан хүсэлтийг журмын 3.1.5-д заасан огноог баримтлан талбай тус бүрээр сонгон шалгаруулалт хийх үнэлгээний дарааллыг тогтооно.

ДӨРӨВ. Сонгон шалгаруулалтын үнэлгээ, үнийн болон оролцогчийн техникийн саналыг үнэлэх

4.1. Сонгон шалгаруулалтын үнийн саналыг үнэлэхдээ дараах журмыг баримтална:

4.1.1. сонгон шалгаруулалтын үнэлгээ нь цахим системийн бүртгэл хаагдсан өдрийн дараагийн ажлын өдрөөс эхлэн нээлттэйгээр явагдана;

4.1.2. комиссын нарийн бичгийн дарга нь тоон гарын үсэг ашиглан журмын 4.1.1-т заасан хугацаанд нийт талбайн хэмжээнд талбай тус бүрээр үнийн саналын жагсаалтыг гаргаж цахим системээр оролцогчдод мэдээлнэ.

4.1.3. комиссын нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалт явуулах талбайн тоо, нэг талбайд санал ирүүлсэн оролцогчийн тоо ажлын ачааллыг тооцож журмын 3.2.4-т заасан дарааллаар оролцогчийн техникийн саналын үнэлгээ явуулах товыг ажлын 3 (гурав) өдөрт багтаан гаргаж цахим системд байршуулна.

4.2. Сонгон шалгаруулалтын үнийн саналын үнэлгээг дараах журмаар хийнэ:

4.2.1. хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид 70 (дал) оноог өгнө. Бусад оролцогчдын ирүүлсэн үнэ бүрийг бүртгэлийн системд бүртгүүлсний дагуу хамгийн өндөр үнэтэй харьцуулж доорх томъёогоор тооцоолно.

Бусад оролцогчийн үнийн санал

Бусад оролцогчийн үнийн саналын оноо = ----- х 70

Хамгийн өндөр үнийн санал

4.2.2. хасагдах үнийн санал ирүүлсэн оролцогчийн үнийн саналыг дараах томъёогоор тооцох ба үнийн саналын оноо нь 40 (дөч) оноонд хүрээгүй техникийн саналд цаашид үнэлгээ хийхгүй бөгөөд цахим хуудсанд байршуулж оролцогч байгууллагуудад мэдэгдэнэ.

Оролцогчийн үнийн санал хасагдах  
оролцогчийн үнийн саналын оноо  $40 < \text{-----} \times 70$

Удаах өндөр үнийн санал

4.2.3.Журмын 4.2.1, 4.2.2-д заасан шаардлагыг хангасан оролцогчдын үнийн саналын үнэлгээний үр дүнг цахим систем автоматаар тухайн сонгон шалгаруулалтад оролцож буй оролцогчдод мэдээлэх бөгөөд комиссын нарийн бичгийн дарга тэмдэглэл үйлдэн комиссын дарга, гишүүдэд танилцуулна.

4.3.Сонгон шалгаруулалтын оролцогчийн техникийн саналыг үнэлэхэд дараах журмыг баримтална:

4.3.1.Хүсэлт, түүнд хавсаргасан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.9-т заасан баримт бичиг нь энэ журмын 3.1-д заасан шаардлагыг хангаагүй бол хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, хүсэлт гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

4.3.2.Комисс нь журмын 4.1.3-д заасан сонгон шалгаруулалтын товын дагуу заасан хугацаанд журмын 4.2-т заасан шаардлагыг хангасан оролцогчийн техникийн саналыг 30 (гуч) хүртэл оноогоор үнэлнэ.

4.3.3.оролцогчдоос ирүүлсэн техникийн санал нь Ашигт малтмалын тухай хуулийн 20.5-д заасан хугацаанд (хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр эрхийн хугацаа) тодорхой үндэслэл тооцоо, судалгаанд тулгуурласан, хэрэгжих боломжтойг төлөвлөсөн эсэхийг харгалзан үнэлгээний хуудас (Журмын 4 дүгээр хавсралт)-т заасны дагуу үнэлнэ.

4.3.4.комиссын гишүүдийн баталгаажуулсан техникийн саналын оноог цахим системд байршуулна.

4.4.Үнийн болон техникийн саналын оноог нэгтгэж шалгаруулахад дараах журмыг баримтална:

4.4.1.комисс нь оролцогчдоос ирүүлсэн үнийн болон оролцогчийн техникийн саналыг журмын 4.2, 4.3-д заасны дагуу үнэлгээний оноог нэгтгэж, хуралдааны тэмдэглэл үйлдэн, дүгнэлт гаргана.

4.4.2.сонгон шалгаруулалтад хоёр болон түүнээс дээш оролцогч нь адил үнэлгээ авсан бол хүсэлтээ цахим системд хамгийн түрүүнд бүртгүүлсэн оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг гаргана.

#### ТАВ. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох

5.1.Сонгон шалгаруулалтын дүнг мэдэгдэх, тусгай зөвшөөрөл олгоход дараах журмыг баримтална:

5.1.1.Комисс нь журмын 4.4-т заасны дагуу оноог нэгтгэн, дүгнэлтээ Ашигт малтмал, газрын тосны газрын даргад ажлын 1 (нэг) өдөрт багтаан хүргүүлнэ.

5.1.2.Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нь Комиссын дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 2 (хоёр) өдөрт багтаан холбогдох тушаалыг гаргана.

5.1.3.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал, газрын тосны газар нь Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-20.7-д заасны дагуу олгоно.

5.1.4.Хэрэв тухайн талбайд шалгарсан оролцогч нь энэ журмын 3.1.3-т заасан үнийн саналд тусгасан мөнгөн дүнг төлөөгүй бол тус оролцогчийн босго үнийг улсын төсөвт төвлөрүүлж, буцаан олгохгүй.

## ЗУРГАА. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт

6.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулахад дараах журмыг баримтална:

6.1.1.Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.9, 49 дүгээр зүйлийн 49.7, 60 дугаар зүйлийн 60.9 дэх хэсэгт заасан талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж зохион байгуулна;

6.1.2.Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж тусгай зөвшөөрлийг цуцалсан, дуусгавар болгосон, холбогдох байгууллагаас хүчингүй болгосон тухай бүр талбайн солбицол, холбогдох мэдээллийг Үндэсний геологийн албанд хүргүүлж байна;

6.1.3.Үндэсний геологийн алба нь чөлөөлөгдсөн талбайд улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд байгаа эсэхэд шүүлт хийж ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг ялгана

6.1.4.Үндэсний геологийн алба нь улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоон Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн ордын улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын тухайн талбайд ногдох зардлын тооцоо, геологи-ашигт малтмалын багц мэдээллийг орд тус бүрээр бэлдэж Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. Тухайн ордын улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын тухайн талбайд ногдох зардал нь сонгон шалгаруулалтын босго үнэ болно.

6.1.5.хувийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоож, Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн ордын үнэлгээг тухайн нөхцөл байдалд зохицуулан үнэлэх, сонгон шалгаруулалтын босго үнийг тогтоох ажлыг Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ;

6.1.6.ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны саналыг авч Засгийн газраар батлуулна.

6.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дараах журмыг баримтална:

6.2.1.Засгийн газраас баталсан талбайг сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ;

6.2.2.ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбай нь Ашигт малтмалын тухай хуулийн хуулийн 24.4-т заасан шаардлагыг хангасан байна;

6.2.3.ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийг баримтална;

6.2.4.ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласан боловч хүсэлт ирээгүй бол сонгон шалгаруулалтыг дахин нэг удаа зарлана. Хэрэв дахин зарлаад хүсэлт ирээгүй талбайг Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн багцад оруулна;

6.2.5.ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үнийн болон техникийн саналыг нээж үнэлэхдээ энэ журмын 3 дугаар зүйлийг баримтлан комисс хэрэгжүүлэх ба сонгон шалгаруулалт явуулсан байгууллага, албан тушаалтны шийдвэрийн хувийг Ашигт малтмал, газрын тосны газартажлын 2 (хоёр) өдөрт багтаан хүргүүлнэ;

6.2.6.ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохдоо Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг баримтална.

ДОЛОО. сонгон шалгаруулалтын комисс бүрэлдэхүүний болон оролцогчийн эрх, үүрэг

7.1.Комиссын бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

7.1.1.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар сонгон шалгаруулалтын комисс (цаашид "Комисс" гэх)-ын бүрэлдэхүүнийг батална. ;

7.1.2.сонгон шалгаруулалтыг тасралтгүй зохион байгуулах, ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс 3 (гурав) хүртэл тооны комиссыг томилж болох бөгөөд комиссын бүрэлдэхүүний 2/3-ийг хагас жил тутамд өөрчилж болно;

7.1.3.комисс нь дарга,нарийн бичгийн дарга болон гишүүдээс бүрдсэн нийт 6 (зургаа) хүний бүрэлдэхүүнтэй байна. Нарийн бичгийн дарга саналын эрхгүй байна.

7.1.4.комиссын гишүүн нь геологи, хууль эрх зүй, эдийн засгийн салбарын мэргэжил эзэмшсэн, геологийн судалгаа, хайгуулын төлөвлөгөө, тайланг үнэлэх мэргэжлийн чадвар, туршлагатай байна. Комиссын бүрэлдэхүүнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба болон салбарын төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна;

7.1.5.Комиссын саналын эрхтэй гишүүдийн 4 ба түүнээс дээш нь журамд заасан хугацаанд үнэлгээ хийж, Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.2-т шаардлага хангасан тоон гарын үсгээр баталгаажуулснаар комиссын үнэлгээ хүчин төгөлдөр болно.

7.2.Комисс нь дараах эрх, үүрэгтэй байна:

7.2.1.сонгон шалгаруулалтыг урилгад заасан хугацаанд эхлүүлэх,

7.2.2.сонгон шалгаруулалт явуулах тухай холбогдох тушаал, шийдвэрийг танилцуулах, оролцогчдоос сонирхсон асуудлаар тайлбар авах,

7.2.3.ирүүлсэн бүх хүсэлт нь энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй бол тухайн сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцож, дахин сонгон шалгаруулалт зарлах тухай дүгнэлт гаргах,

7.2.4.сонгон шалгаруулалтын үйл явцыг баримтжуулж, тухай бүр тэмдэглэл үйлдэх,

7.2.5.сонгон шалгаруулалтын журамд хугацаа заасан үйл ажиллагаануудыг тодорхой шалтгааны улмаас хугацаанд нь багтаан явуулах боломжгүй болсон тохиолдолд комиссын гишүүдийн хурлаар шийдвэрлэн оролцогчдод мэдэгдэн хугацааг өөрчилж, сунгаж болно.

7.2.6.Комиссын гишүүд нь Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад хуульд заасан мэдээллийг задлах, нийтлэх буюу тарааж болохгүй.

7.3.Комиссын дарга, гишүүд нь дараах эрх, үүрэгтэй:

7.3.1.Комиссын дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.3.1.1.Комиссын хурлыг удирдаж, үйл ажиллагаатай холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүр шуурхай авч нэгдсэн удирдлагаар хангана;

7.3.1.2.Комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох баримт бичигтэй тухай бүр танилцах, комиссын гишүүдэд шаардлага тавьж ажиллана;

7.3.2.Комиссын гишүүд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.3.2.1.Комиссын хуралд саналын эрхтэйгээр холбогдох үнэлгээ хийж оролцох;

7.3.2.2.Комиссын гишүүд журамд заасан хугацаанд багтааж үнэлгээ хийх;

7.3.2.3.Комиссын хуралд тогтмол оролцож, комиссын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах;

7.3.2.4.Комиссын хуралдаанаар хэлэлцэх оролцогчдоос ирүүлсэн хүсэлтэд мэргэжлийн санал, дүгнэлтийг гаргаж оролцох;

7.3.2.5.Комиссын дарга, гишүүд нь комиссын гишүүний эрх, үүргийг нэг адил хэрэгжүүлэх;

7.3.2.6.Комиссын гишүүн өөрийн биеийн эрүүл мэндийн шалтгаан болон бусад шалтгаанаар комиссын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт гаргах.

7.3.2.7.Ашиг сонирхлоос ангид байх.

7.4.Комиссын салбар хуралдааны нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байна:

7.4.1.Нарийн бичгийн дарга нь журмын 2.5.4-д заасан хугацаа дуусмагц ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2-т заасны дагуу тусгай тэмдэглэгээг хийх.

7.4.2.Нарийн бичгийн дарга нь хүсэлтэд үнэлгээ хийхгүй бөгөөд шалгаруулалттай холбоотойгоор хурлын тэмдэглэл хөтлөх, цахим хэлбэрээр ирүүлсэн сонгон шалгаруулалтын материалыг хуулбарлаж архивлахдаа Комиссын даргаар баталгаажуулан архивт хүлээлгэх;

7.4.3.Журмын 4.3.2, 4.3.3-д заасан үнэлгээний нэгтгэлийг бэлтгэж комисст танилцуулах;

7.4.4.Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

7.4.5.Комиссын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах;

7.4.6.Хууль хяналт, шүүхийн эрх бүхий байгууллагаас Комисстой холбоотой асуудлаар маргаан шийдвэрлэх, хяналт, шалгалт хийх тохиолдолд шаардлагатай баримт, мэдээллийг тухай бүрд нь гаргаж өгөх.

7.5.Оролцогч нь дараах эрх, үүрэгтэй байна:



7.5.1.сонгон шалгаруулалтын журамтай танилцаж судалсан байх;

7.5.2.сонгон шалгаруулалтын урилгаар зарласан 1 (нэг) болон түүнээс олон талбайд хүсэлт ирүүлэх;

7.5.3.Комиссын гишүүдийн баталгаажуулсан үнэлгээний өөрт хамаарах хэсэгтэй хэсэгчлэн танилцах;

7.5.4.хүсэлтэд ирүүлсэн баримт бичгийг үнэн зөвийг бүрэн хариуцна.

7.5.5.сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Сонгон шалгаруулалтын комисст бичгээр гаргах.

НАЙМ. Бусад зүйл

8.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд дараах хариуцлага хүлээлгэнэ:

8.1.1.сонгон шалгаруулалт оролцохоор ирүүлсэн баримт бичиг нь энэхүү журмын 3.1-д заасан шаардлагыг хангаагүй, баримтаар нотлогдоогүй, холбогдох байгууллагаас олгосон хуулийн этгээдийн болон татварын албаны тодорхойлолт, боловсролын үнэмлэх, гэрчилгээ, тоног төхөөрөмжийн гэрчилгээ зэрэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, эсхүл сонгон шалгаруулалтад оролцох зорилгоор тэдгээр бусдын баримтад засвар, өөрчлөлт оруулж ашигласан нь илэрхий байвал комисс үнэлгээ хийхээс олонхийн саналаар татгалзаж, энэ тухай хурлын тэмдэглэлд тусгана;

8.1.2.үнийн болон техникийн саналыг үнэлэх явцад комиссын дарга, гишүүн, нарийн бичгийн дарга нь энэхүү журамд заасныг зөрчиж, эрх мэдлээ урвуулан ашигласан бол Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ;

8.1.3.энэ журамд заасныг зөрчсөн нь нотлогдож, холбогдох хариуцлага хүлээхээр болсон Комиссын дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг дахин комиссын бүрэлдэхүүнд оролцуулахгүй.

8.2.Маргааныг хянан шийдвэрлэхэд дараах журмыг баримтална:

8.2.1.сонгон шалгаруулалтын үе шатад комисс нь тухайн оролцогчийн эрх ашгийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гаргасан гэж үзсэн оролцогч тухайн өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан Ашигт малтмал, газрын тосны газрын даргад бичгээр гомдол гаргаж болно.

8.2.2.Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нь журмын 8.2.1-д заасан гомдлыг хүлээн авмагц цахим системд мэдээлэн, тухайн талбайн үнэлгээг зогсоож, гомдолд хамаарах комиссоос бусад комиссоор дахин хянуулж, ажлын 5 хоногт багтаан хэрхэн шийдвэрлэсэн талаарх хариуг гомдол гаргагчид мэдэгдэнэ.

8.2.3.сонгон шалгаруулалтад оролцогч нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

8.3.Бусад.

8.3.1.Шалгарсан оролцогчийн техникийн саналд хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх, түүнийг хайгуулын ажлын жилийн тайланд

тайлагнасан эсэхэд Ашигт малтмал, газрын тосны газар хяналт тавьж Ашигт малтмалын тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллана.